

БАТЛАВ. МУИС-ИЙН ЭРДЭНЭТ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ДОК.ПРОФ Т.ЭНХ-АМГАЛАН



МУИС-ИЙН ЭРДЭНЭТ СУРГУУЛИЙН МАГИСТРАНТ
ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН
УДИРДАМЖ

2018-03-22

НЭГ. ЗОРИЛГО

Оюутнуудыг судалгаа шинжилгээний ажилд оролцуулах, дадлагажуулах, тэдний эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийг нийтэд таниулан сурталчлах, дэмжих, бүтээлч сэтгэлгээ, багш оюутнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, онол практикын мэдлэгийн уялдаа холбоог сайжруулах, магистрын дипломын ажил бичихэд заавар зөвөлгөө өгөх, төсөл хөтөлбөрт хамруулах боломж бий болгоход оршино.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Эрдэм шинжилгээний хуралд оролцох хүсэлтэй оюутнууд хэлэлцүүлэх илтгэлийн сэдэв, удирдагчийн нэрийг 2018 оны 04 сарын 13-ны дотор харьяа тэнхимийн эрхлэгч нарт бүртгүүлсэн байна.

2.2. Оюутны эрдэм шинжилгээний бага хурал 2018 оны 04 сарын 20-ны өдөр (Баасан) 14 цагт 305 тоот лекцийн танхимд болно.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. МУИС-ийн Эрдэнэт сургуулийн магистрын түвшний оюутнууд оролцоно.

3.2. Эрдэм шинжилгээний хуралд илтгэлээ дараах чиглэлийн хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Эдийн засаг, математик
- Менежмент, маркетингийн удирдлага
- Нягтлан бодох бүртгэл
- Банк, санхүү гэсэн ерөнхий хүрээг харгалзан үзэж сэдвээ нарийвчлан тодорхойлсон байна.

ДӨРӨВ. ИЛТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Боловсруулалт: Илтгэлийг цаасаар болон электрон хэлбэрээр авна. Илтгэлийг бага хуралд хэлэлцүүлэхэд Power Point программ дээр бэлтгэж, электрон (файлаар 2-3 хувь) хэлбэрээр хурал болох өдөр бэлтгэж ирнэ.

4.2. Ерөнхий шаардлагууд:

- ✓ Илтгэлийг А4 цаасан дээр форматын дагуу бичих
- ✓ Үсгийн фонт: Times New Roman
- ✓ Бичвэрийн хэмжээ: 12
- ✓ Мөр хоорондын зай: 1,5
- ✓ Top -1.5cm, bottom -2cm, left -3cm, right -1.5cm

- ✓ Илтгэл 4-8 нүүр байх (Илтгэл нь оршил, онолын хэсэг, эмпирик судалгааны хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгээс бүрдэнэ)
- ✓ Илтгэлд эх зохиолоос авч хэрэглэсэн зүйлийг ишлэлд авч, зүүлтийг зохих журмын дагуу (foot note, end note эсвэл хаалтад зохиогчийн нэр, ном, бүтээлийн хуудсыг тэмдэглэж) хийх
- ✓ Ном зүйд зохиогчийн нэр, овгийн эхний үсэг, хэвлэсэн он, номын эсвэл өгүүллийн нэр, хэвлэсэн газар буюу хот гэсэн дарааллаар бичих
- ✓ Нүүрэн талд сургууль, сэдвийн нэр, өөрийн овог нэр, хөтөлбөр, түвшин, удирдагчийн нэр бичих
- ✓ Илтгэлийг шаардлагын дагуу бичиж 2-3 хувь хэвлэсэн байх
- ✓ Илтгэл тавих хугацаа 7 минут, асуулт хариулт 5 хүртэлх минут байна.

4.3. Агуулга:

- ✓ Орчин үеийн онол, практикын шинэ чиг хандлага, арга хэлбэр, туршлага, үр дүнгийн асуудлыг хөндсөн байх
- ✓ Шинжлэх ухааны онол арга зүйд үндэслэсэн тодорхой аргачлалыг хэрэглэсэн байх
- ✓ Шинэлэг санаа дэвшүүлсэн байх
- ✓ Бодит мэдээлэл ашиглан баримтаар баталгаажуулах судалгаа хийгдсэн байх (загвар, графикаар харуулсан байх)
- ✓ Ишлэл зүүлтийг зохих журмын дагуу хийсэн байх
- ✓ Ашигласан ном, материалын жагсаалт гаргасан байх

ТАВ. ДҮГНЭХ ЖУРАМ

5.1. Хуралд тавигдах илтгэлүүдийг комиссын гишүүд шүүн, тодорхой шалгуурын дагуу дүгнэн байр эзлүүлнэ.

5.2. Дүгнэх шалгуур

- ✓ Сэдвийг эзэмшсэн байдал
- ✓ Судалгааг боловсруулсан байдал, бүтэц
- ✓ Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол
- ✓ Илтгэх чадвар
- ✓ Шинжлэх ухааны баримт нотолгоо дэвшүүлсэн байдал

5.3. Байр

1-р байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал

2-р байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал

Тусгай байр – Өргөмжлөл, дурсгалын зүйл